



“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

_____ оны _____ сарын _____ өдөр

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК -ийн хувьцаа эзэмшигчдэд

Бид Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн Гүйцэтгэх удирдлагын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн ажил гүйлгэнд тохирох нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгон авч хэрэглэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг үнэн зөв хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлийг агуулаагүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, энэхүү үйл явцтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх асуудал багтана.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн энэхүү санхүүгийн тайлангийн талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм.

Бид танай санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, Аудитын Олон улсын Стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, манай компанийн “Аудит хийх журам”-ыг баримтлан хийв. Аудит хийхдээ түүвэрлэсэн анхны баримтаас тайлан хүртэл хөөн шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, задлан шинжлэх, асууж ярилцах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Бидний хийсэн аудит нь санхүүгийн тайлангийн талаар санал, дүгнэлтээ илэрхийлэх хангалттай үндэслэлийг бий болгосон гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр энэхүү санхүүгийн тайланнь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

Бусад

Энэ дүгнэлтийг өөр аливаа нэг этгээдэд биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан, тэдний хүсэлтээр хийсэн аудитад үндэслэн гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



ЗАХИРАЛ

№4872 33.5005766

Т.СУГАРСҮРЭН